



САЙХАН СУМЫН
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020-07-30 № 07-2020/04-НА-29
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Сайхан сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Сайхан сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Сайхан сумын Ардчилсан намын хорооны Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сайхан сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр
1...5... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сайхан сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

УРИА: САЙХАНЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөрийн зорилт нь эдийн засаг, нийгэм, засаглалын гурван тулгуурт бодлогыг хэрэгжүүлэн, төрөлжсөн эдийн засагтай, чанар, хүртээмжтэй нийгмийн суурь үйлчилгээг үзүүлсэн, шударга засаглал бүхий бүтээгдүмүлгэртэй жишиг сум болгоход оршино.



НЭГ. ЭДИЙН ЗАСАГ

- Аж үйлдвэр
- Хөдөө аж ахуй
- Дэд бүтэц, аялал жуулчлал

1.1 Аж үйлдвэр

- 1.1.1. Цемент-Шохойн үйлдвэрийг түшиглэн бетон, төмөр хийц, барилгын материалын үйлдвэрийг ашиглалтанд оруулах замаар аж үйлдвэрийн төв болгон хөгжүүлэх бодлогыг баримталж ажиллана.
- 1.1.2. Гангийн болон барилгын жижиг дунд үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 1.1.3. Хог хаягдлын менежментийг сайжруулж, төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор үнс цуглуулах цех байгуулах замаар Цемент-Шохойн үйлдвэрийн түүхий эдийг бэлтгэх ажлын төсөв тооцоо эдийн засгийн үр өгөөжийг тооцон үйлдвэрлэлийг эхлүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.1.4. Хог дахин боловсруулах үйлдвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 1.1.5. Томоохон аж ахуйн нэгж, компаниудын хүнсний болон ахуйн хэрэгцээний бараа, бүтээгдэхүүнийг орон нутгийн аж ахуй нэгж, үйлдвэр эрхлэгчдээс хангах ажлыг зохион байгуулна.
- 1.1.6. Бизнес эрхлэгчдийг оновчтой тодорхойлж, баялаг бүтээгчдийн хэрэгцээнд үндэслэн бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.1.7. Жижиг дунд үйлдвэрлэгч нарыг бодлогоор дэмжиж, бодит дэмжлэг үзүүлнэ.

1.2. Хүнс хөдөө аж ахуй

- 1.2.1. Малын үүлдэр угсааг сайжруулж, нийт малд өндөр ашиг шимт болон нутгийн шилмэл үүлдрийн малын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.
- 1.2.2. Нийтийн эзэмшлийн ухаалаг системтэй худгийг зайлшгүй шаардлагатай газруудад нэмж гаргана.
- 1.2.3. Хадлан, дарш бэлтгэх, тэжээлийн үйлдвэрлэл эрхлэхийг бодлогоор дэмжиж, малчдыг хадлангийн техник хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 1.2.4. Малчдын бэлчээрт ойрхон тариалангийн талбайг тусгаарлах хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж, тариалан эрхлэгч нартай хамтран тариалангийн талбайг хашлага хаалттай болгох ажлыг зохион байгуулна.

- 1.2.5. Төмс хүнсний ногоо тариалагчдыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж, борлуулалтыг нэмэгдүүлэхэд бодлогоор дэмжинэ.
- 1.2.6. Тариалангийн газар эзэмших, ашиглах эрхийн хяналтыг сайжруулж, хөрсний үржил шим бууруулсан эсэхэд хяналтыг сайжруулж, эрх зүйн зохицуулалтыг мөрдүүлнэ.
- 1.2.7. Гахай, шувуу, зөгий, загас болон бусад туслах аж ахуйг өрх, фермерийн аж ахуйн түвшинд эрхлэхийг дэмжин ажиллана.
- 1.2.8. Өвөл, зуны хүлэмж барих ажлыг дэмжиж ажиллана.

1.3. Дэд бүтэц, аялал жуулчлал

- 1.3.1. Хүүхдийн паркийг олон улсын жишигт нийцсэн "Гэрэлт гудамж", "Бахархлын гудамж", "Байгууллагуудын нэрэмжит гудамж", "Хэвтээ болон босоо тэмдэглэгээтэй дугуйн болон рольк, скүүтерийн зам, задгай театр бүхий "Цэцэрлэгт хүрээлэн"-г шинэчлэн барьж байгуулахад олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллана.
- 1.3.2. Сайхан сумын Ерөнхий төлөвлөгөөний дагуу суурьшлын бүсийн дахин төлөвлөлтийг хийж "Шинэ суурьшлын бүс"-ийг байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 1.3.3. Хөтөл хотыг тэлж хөгжүүлэх бодлогын хүрээнд төр, хувийн хэвшлийнхэнтэй хамтарч "Амар тайван чуулган"-ы ойролцоох газарт инженерийн магестрал шугам татаж, барилгажих нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- 1.3.4. Хүүхэд, залуучуудын хөгжлийн ордоныг шинээр барьж байгуулах саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгах тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.5. Ахмадууддаа зориулсан "Ахмадын өргөө"-г барьж байгуулах саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгах тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.6. Бичил хороолол дундах "Стандарт"-ыг бий болгож ногоон байгууламжийг нэмэгдүүлж эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.3.7. Сайхан сумын доторх болон үйлдвэрийн орчмын замуудыг өргөтгөн шинэчлэх, авто замыг асфальтан хучилттай болгох, болон Жимстэй хорооллын замыг сайжруулах ажлыг аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллана.
- 1.3.8. Бичил хороолол дундах авто машины зогсоол, хурд сааруулагчийг стандартын дагуу хийх ажлыг олон нийтийн санал санаачилгад үндэслэн шийдвэрлэнэ.
- 1.3.9. Мэдээллийн технологи харилцаа холбооны хамрах хүрээг тэлж, өндөр хурдны интернэтийн хурдыг өргөтгөх ажлыг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй оператор компаниудтай хамтарч гүйцэтгэнэ.
- 1.3.10. Гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 1.3.11. Хөтөл хөшөөнөөс төмөр замын гарам хүртэлх зам дагуу 2 талд нэг эгнээ шилмүүст мод, нэг эгнээ навчит гэсэн ангиллаар мод тарьж, арчлан ургуулах ажлыг аж ахуй нэгжүүдийг уриалан хамтран зохион байгуулна.
- 1.3.12. Бүх орон сууцны дээвэр болон гадна фасадны засварын саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгах тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.13. Наадмын талбайг шинэчлэн засварлах ажлыг олон нийтийн санал санаачилгад үндэслэн шийдвэрлэнэ.
- 1.3.14. Зураг, төсөв нь хийгдсэн Жимстэй хороололруу 500 метр инженерийн шугам татаж хэрэглэгчдэд хүргэх саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгах тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.15. Номгон тосгонд залуучуудын чөлөөт цагийг өнгөрөөх шинэ "Спорт заал" барьж байгуулах саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгах тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.16. Номгон тосгоны 1,2 км сайжруулсан шороон замыг хатуу хучилттай болгох саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгах тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.17. Гэр хороолол болон Номгон тосгонд гэрэлтүүлэг хийж, аюулгүй орчинг бий болгоно.

- 1.3.18. Сайхан сумын хэмжээнд камержуулалтыг нэмэгдүүлж, аюулгүй орчинг бүрдүүлнэ.
- 1.3.19. Овоот, Дөмбөн хорооллын инженерийн шугамын өргөтгөлийг хийж улирал харгалзахгүй цэвэр ус хэрэглэх боломжийг бүрдүүдэх саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгах тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.20. "Жорлонгоо өөрчилье" ТББ-тай хамтран "Эко жорлон" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.21. 2020 оны улсын төсөвт суугдсан Спортын ордныг ашиглалтанд оруулахад шаардлагатай хөрөнгийн саналыг холбогдох байгууллагад уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалаар шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж холбогдох байгууллагад уламжилна.
- 1.3.22. Гэр хороололд хүүхдийн цэцэрлэгийг төрийн болон хувийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулах саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгах тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.23. Худалдаа, үйлчилгээ, бизнес эрхлэгчдийн ажиллах таатай орчинг бүрдүүлж шинээр Худалдааны төв байгуулах саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгах тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.24. Номгон тосгоны уурын зуухны шинэчлэлт, гэр хороололд инженерийн шугам татаж ашиглалтанд оруулах саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгах тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.25. Номгон тосгоны төвийн үерийн хамгаалалтыг засварлан шинэчлэх ажлыг олон нийтийн санал санаачилгад үндэслэн шийдвэрлэнэ.
- 1.3.26. Номгон тосгоны 24 айлын орон сууцны дээвэр засварлах саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд суулгах тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.27. Номгон тосгонд нэн шаардлагатай байгаа Хүн эмнэлгийн барилгыг барих саналыг холбогдох байгууллагад уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтанд тусгуулах ажлыг зохион байгуулна.

ХОЁР. НИЙГЭМ

- Эрүүл мэнд
- Боловсрол
- Хөдөлмөр эрхлэлт

2.1. Эрүүл мэнд

- 2.1.1. Эрүүл мэндийн даатгалаас олгогддог эмийн хөнгөлөлтийг тэгш, хүртээмжтэй олгох асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.1.2. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах аян өрнүүлж, халдварт, халдварт бус өвчлөлийг бууруулах ажлыг зохион байгуулна.
- 2.1.3. Сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг орчин үеийн стандарт шаардлагад нийцүүлэн үе шаттайгаар шийдвэрлүүлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжлан хөрөнгө оруулалтуудыг шийдвэрлүүлнэ.
- 2.1.4. "Явуулын эмнэлэг"-ийн үйлчилгээг нэвтрүүлж, иргэдийг 2 жил тутамд эрүүл мэндийн үзлэгт хамруулна.
- 2.1.5. Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, эмийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаад, дотоодын ижил төстэй эмнэлгүүдэд даван сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 2.1.6. Олон нийтийн оролцоонд тулгуурлан "Архидалтай тэмцэх" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.1.7. Олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн халамж, үйлчилгээг сайжруулна.
- 2.1.8. "Дугуйтай Хөтөлчүүд" аяныг санаачлан хэрэгжүүлнэ.

2.2. Боловсрол

- 2.2.1 Ерөнхий боловсролын сургуулийн дэргэд Техник, Мэргэжлийн сургалтын ангийг байгуулах Цемент-Шохойн үйлдвэр болон Төмөр бетон дэрний үйлдвэрийн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх асуудлыг холбогдох мэргэжлийн байгууллагад уламжлана.
- 2.2.2 Цемент-Шохойн үйлдвэрийн сургалтын төвийг түшиглэн МСУТ байгуулах ажлын саналыг холбогдох байгууллагад нь уламжилна.
- 2.2.3 Оюун ухааны академийн албан ёсны салбарыг нээж оюуны спортын тамирчдыг олон улсад гаргах боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.4 "Гадаад оюутан" хөтөлбөрийг хэрэгжүүлж Сайхан сумаас 50 хүртэлх оюутанг гадаадад сургах боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.5 Овоот, Дөмбөн, Жимстэй хороололд амьдарч буй сурагчдад зориулж сургуулийн автобусаар үйлчлэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.6 Шилдэг багш, суралцагчдыг гадаад, дотоодын сургуулиудад суралцуулах, дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 2.2.7 Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хүрээнд улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулна.
- 2.2.8 "Оюунлаг Сайханчууд" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.2.9 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэний нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлсэн үйлчилгээг дэмжиж ажиллана.
- 2.2.10 Сайхан сумаас улсын болон олон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцож буй хүүхэд, залуучуудыг бодлогоор дэмжин ажиллана.
- 2.2.11 Сургуулийн дотуур байрыг шинээр барих замаар хүн ам өсөх, зах зээл тэлэх боломжийг бүрдүүлнэ.

2.3 Хөдөлмөр эрхлэлт

- 2.3.1 "Өрх бүр-Ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.3.2 Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, ажлын байр шинээр бий болгоно.
- 2.3.3 Зорилтот бүлэг болон амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой иргэдийг тэргүүн эгнээнд ажлын байраар хангана.
- 2.3.4 Сайхан сумын 40-өөс дээш насны иргэдийг ажлын байраар хангах зорилгоор Сум хөгжүүлэх сангийн зээлийн эх үүсвэрийн 30 хүртэлх хувийг зорилтот бүлэгт бизнесийн зориулалтаар олгож, сонгон шалгаруулалтыг нээлттэй цахим болгоно.
- 2.3.5 Удаан хугацаагаар гэртээ хүүхэд асарч, ажил эрхлээгүй эмэгтэйчүүд, ганц бие эцэг эхчүүдийг төрийн байгууллага, томоохон аж ахуйн нэгжүүдээс боломжит ажил үйлчилгээг туслан гүйцэтгүүлэх, ажлын уян хатан нөхцөл бүхий цагийн ажлаар хангах, нийгмийн амьдралд татан оролцуулах ажлыг зохион байгуулна.
- 2.3.6 Төрийн бус байгууллагуудтай хамтран эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.

ГУРАВ. ЗАСАГЛАЛ

- Бүтээлч, авлигагүй засаглал
- Чадварлаг төрийн алба
- Иргэдийн оролцоо, хяналт

- 3.1.1 Төрийн байгууллагын үйл ажиллагааг хүртээмжтэй, нээлттэй болгож, төрийн албан хаагчдыг хүнд сурталгүй, авлигаас ангид байх нөхцөлийг бүрдүүлж, "Авлигагүй, нээлттэй, цахим" сум болгоно.
- 3.1.2 Үе үеийн Засаг дарга нарын Зөвлөл байгуулж төрийн залгамж халааг бий болгоно.
- 3.1.3 Сум хөгжүүлэх сангийн зээлийн эх үүсвэрийн зарцуулалт, шалгаруулалтыг ил тод, цахим болгоно.
- 3.1.4 Хөтөл хотын хилийн цэсийн асуудлыг шат шатны холбогдох байгууллагуудад уламжилж, Хот төлөвлөлт, өргөжин тэлэх боломжийг бүрдүүлнэ.
- 3.1.5 Цемент-Шохойн үйлдвэртэй орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр нийгмийн хариуцлагын гэрээг байгуулж хамтран ажиллана.

- 3.1.6 Хөтөл, Номгон аппликейшн хийж мэдээ мэдээллийг цаг тухайд нь мэдээллэх, цахим орчинг бий болгоно.
- 3.1.7 Сууц өмчлөгчдийн холбоодыг үйл ажиллагааг дэмжин урамшуулах бодлого баримталж ажиллана.
- 3.1.8 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон зорилтот бүлгийн өрхөд зориулж түрээсийн байрны үйлчилгээ нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 3.1.9 "Хашаандаа сайхан амьдаръя" хөтөлбөрийг хэрэгжүүлж өрх бүрийг ногоон байгууламж хийх нөхцөл бололцоог ханган урамшуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.1.10 Гавшгай багийн төвийг Овоот хороололд байгуулж өрхийн эмнэлэг, хүүхдийн цэцэрлэг, цагдаагийн постыг байгуулж төрийн үйлчилгээг ойртуулна.
- 3.1.11 Төрийн захиргааны албан хаагчдыг ард, иргэд, олон нийт үнэлдэг системийг бий болгож, хариуцлагын тогтолцоог мөрдүүлнэ.
- 3.1.12 Хүний эрхийг хамгаалахад төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.1.13 Хүүхдийг бүх төрлийн хүчирхийлэлд өртөх, хөдөлмөр эрхлэх, сургууль завсардах, аюултай орчинд амьдрахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн гэр бүл, сургууль, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.1.14 Хүүхдийг ёс суртахуун, зан заншлын буруу зуршилд автахас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн гэр бүл, сургууль, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.1.15 Сумын хурдан морин уралдааны замыг тогтоон, замын нөхцөлийг сайжруулж, унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангана.
- 3.1.16 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэхэд идэвхи санаачилга, үр дүнтэй оролцож буй иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдийг урамшуулна.
- 3.1.17 Гадаад орнууд болон бүс нутгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн, ижил түвшний аймаг, бүс, мужтай холбоо тогтоож, хамтран ажиллана.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНЫ ДАРГА



Б.МӨНХБОЛД

